



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 9/148

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх хугацаанд “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтын түр журам”-ыг нэгдүгээр, “Хөл хорионы хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй хамрагдах үйлчлүүлэгчийн зорчих эрхийн зөвшөөрлийн хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийслэлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянтогтох/, нийслэлийн Эрүүл мэндийн газар /Б.Бямбадорж/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141210284

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
01 сарын 10 өдрийн 1/12 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮР ЖУРАМ

Нэг. Үндэслэл

1.1. Нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлыг зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад энэхүү журмыг баримтална.

1.2. Эрүүл мэндийн байгууллагууд тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэн, хүн ёсны харилцааны хэм хэмжээ, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг чанд мөрдөн, хариуцлагатай ажиллах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, шуурхай үйлчлэхэд онцгой анхаарч ажиллана.

Хоёр. Эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах чиглэлээр

2.1. Эрүүл мэндийн байгууллага бүр иргэдэд мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл өгөх 24 цагийн ажиллагаатай утсыг гаргаж, албан хаагчийг томилгоожуулах;

2.2. Эрүүл мэндийн байгууллага амбулаторийн шүд, мэс засал, дотор, эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд, дүрс оношилгооны үзлэгийн кабинетыг ажиллуулах, бусад кабинетыг тусламж, үйлчилгээний онцлогоос хамаарч зохицуулалтын арга хэмжээг авах;

2.3. Өдөр бүр эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдах шаардлагатай иргэдийн /гемодиализ, хавдрын хими эмчилгээ, төрөх эмэгтэйчүүд, мэс заслын боолт/ судалгааг шинэчлэн гаргаж, энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу дүгнэлтийг бүрэн гүйцэд бөглөн баталгаажуулж, иргэний үнэмлэхийн хамт хүчин төгөлдөр зорчих эрх бүрдэхийг иргэнд онцгой анхааруулах;

2.4. Лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай цахимаар болон телемедицинээр холбогдож зөвлөгөө авах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах;

2.5. Үйлчилгээний танхим, үзлэгийн кабинет, хэвтэн эмчлүүлэх тасаг, аж, ахуй нэгж, байгууллагуудын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд хяналт тавих;

2.6. Коронавируст халдварын эмнэлэгт суурилсан тандалтыг чанартай зохион байгуулах;

2.7. Үйлчлүүлэгчдийг QR код уншуулах, амбулаторийн үзлэгийн кабинет, оношилгооны болон хэвтэн эмчлүүлэх тасаг, эргэлтийн хэсэгт QR кодыг байршуулж, уншуулах зөвлөмжөөр хангах;

2.8. Эмнэлгийн дулаан, цахилгаан, харилцаа холбоо, бусад дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангаж, шаардлагатай тохиолдолд ашиглах нөөц эх үүсвэрүүдийг бэлтгэх;

2.9. Хатуу хөл хорио тогтоож, хэвтэн эмчлүүлэгчийн эргэлтийг зогсоосонтой холбогдуулан сахиурын хоолыг зохицуулах арга хэмжээг авах;

2.10. Ар гэрийг зайлшгүй дуудах нөхцөл үүссэн, тохиолдолд 94948327 дугаарын утсаар нийслэлийн онцгой комиссын дугаарын утсаар холбогдох мэдээллийг өгч шийдвэрлүүлэх;

2.11. Хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, зайлшгүй шаардлагатай, яаралтай тусламжийн эм, тариа, ороох боох материал, цус цусан бүтээгдэхүүний бэлэн байдлыг тогтвортой хангах, нөөцийг бүрдүүлэх;

2.12. Коронавируст халдварын сэжигтэй тохиолдлыг тусгаарлан ажиглах өрөөг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах;

2.13. Коронавируст халдвар (КОВИД 19)-ын 1-р хавьтал (эрсдэл өндөр ба бага)-ыг гэрт нь тусгаарлан хянах ба хяналт тандалтыг өрхийн эрүүл мэндийн төв өдөр бүр хийж, харъяа дүүргийн ЭМТ-д холбогдох журмын дагуу мэдээллийг хүргүүлэх;

2.14. Товлолт дархлаажуулалтыг хөл хорионы хугацаанд хойшлуулж, төлөвлөгөөт хугацаанд нөхөн хамруулах;

2.15. Алсын болон ойрын түргэн тусламжийн дуудлагын хариу арга хэмжээ шуурхайн авч, шаардлагатай зөвлөгөө мэдээллийг өгөхөд онцгой анхаарах, дуудлагад явах унааг бэлэн байлгах, шатахууныг хангалттай хэмжээгээр нөөцлөх.

Гурав. Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах

3.1. Хөл хорионы хугацаанд өөрийн байгууллагын тусламж, үйлчилгээний онцлогт нийцүүлэн хүний нөөцийн ажиллах хуваарь, ээлжийн зохицуулалтыг хийж баталгаажуулан, эрүүл мэндийн ажилтанд танилцуулах;

3.2. эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилчдын ээлжийн зохицуулалтыг хөл хорионы хугацаанд тээврийн хэрэгслийн үйлчлэх хуваарьт нийцүүлэн зохион байгуулах;

3.3. Эрүүл мэндийн байгууллагын бүх ажилтан, албан хаагчид ажлын үнэмлэхийн биедээ авч явахыг онцгой анхааруулах;

3.4. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд улсын хэмжээнд орлуулж болохгүй тусламж, үйлчилгээний хүний нөөцийн төлөвлөлтөд онцгой анхаарах, нөөц мэргэжилтнүүдийг томилгоожуулах ажиллах хуваарийг гаргах;

3.5. Яаралтай тусламжийн тасагт ажиллах эмнэлгийн мэргэжилтнийг нэмэгдүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг хангах, эрсдэлийг тооцож, дайчлан ажиллах хүний нөөцийн хуваарийг гаргах;

3.6. Шаардлагатай тохиолдолд дайчлах багийг дуудах мэдээллийн урсгалыг тодорхой болгож, хариуцах албан тушаалтныг үүрэгжүүлэн, бэлэн байхыг анхааруулах;

3.7. Эмнэлгийн яаралтай тусламж, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг, нэгжийн ор, хүний нөөц, түргэвчилсэн оношлуур, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллах;

3.8. Алсын болон дуудлага өгсөн эрүүл мэндийн байгууллагад газар дээр нь очиж тусламж, үйлчилгээ үзүүлэх багийн бэлэн байдлыг хангах;

3.9. Хөл хорионы хугацаанд өрхийн эрүүл мэндийн байгууллага 1 эмч, 1 сувилагчийн бүрэлдэхүүнтэй баг 10:00-16:00 хугацаанд өдөр бүр ажиллах зохион байгуулах.

Дөрөв. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шуурхай хамруулах

4.1. Эрүүл мэндийн байгууллага байнгын хяналтад байдаг иргэдэд зөвлөгөө мэдээллийг нээлттэй авах боломжийг бүрдүүлж, мэдээлэл авах утасны дугаарыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, нийтэд түгээх арга хэмжээг зохион байгуулах;

4.2. Өрхийн эрүүл мэндийн төв нь иргэдээс санал хүсэлт авч, зөвлөгөө мэдээлэл өгөх 24 цаг нээлттэй ажиллах утас ажиллуулж, эмч нарыг томилгоожуулж, утас, цахимын хаягийг хороо, дүүргийн засаг захиргааны байгууллагатай хамтран иргэдэд түгээх, үйл ажиллагааг зохион байгуулах;

4.3. Эрсдэлт бүлгийн хүн амын /5 хүртэлх насны хүүхэд, 65 наснаас дээш өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сүрьеэ, гемодиализ, хавдар, архаг өвчтэй иргэд, дархлаа дарангуйлах эм хэрэглэдэг/ судалгааг гарган, эрүүл мэндийн хувьд байнгын хяналт шаардлагатай иргэдийг утсаар болон цахимаар хянах, зөвлөгөө өгөх;

4.4. Хөнгөлөлттэй эм авах үйлчилгээг тасалдахаас сэргийлж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэргэжилтэнд amarjargal.b@emd.gov.mn цахим шуудангийн хаягаар үйлчлүүлэгчийн холбогдох мэдээллийг тухайн өдөрт нь багтаан ээлжийн эмчид цаг алдалгүй хүргүүлнэ;

4.5. Яаралтай тусламжийн тусгаарлан ажиглах хэсэгт байгаа иргэнийг шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээнд хугацаа алдалгүй хамруулахад онцгой анхаарах;

4.6. Эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхэд, нярайд гэрийн эргэлтээр болон утсаар зөвлөгөө мэдээллийг өгөхөд онцгой анхаарах, зөвлөгөө өгөх утасны дугаарыг иргэдэд түгээх;

4.7. Яаралтай эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнд (эх барих эмэгтэйчүүдийн тусламжаас бусад) харьяалал харгалзахгүй үйлчлэх бөгөөд бусад эрүүл мэндийн байгууллагад хандуулж иргэнийг буцаахгүй байх;

4.8. Эрүүл мэндийн байгууллага шаардлагатай тохиолдолд телемедицинээр төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөгөөг авах, баг дуудах, эмч нарын хамтарсан үзлэгийг хугацаа алдалгүй зохион байгуулах;

4.9. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тусгаарлан ажиглах хэсэгт коронавируст халдварын сэжигтэй тохиолдол болон ойрын болон дам хавьтлын гемодилиз эмчилгээг үргэлжлүүлэх.

Тав. Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээнд хамруулах

5.1. Өвчтөн шилжүүлэхдээ шилжүүлэх эмнэлэгт урьдчилан мэдэгдэж, дуудлага өгч, цахимаар болон телемедицинээр холбогдож оношилгоо, эмчилгээний мэдээллийг солилцон, харилцан тохиролцож шийдвэрлэсний дагуу эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох журмыг баримтлан зохион байгуулах;

5.2. Өвчтөнийг эмнэлэг хооронд тээвэрлэх хугацаанд иргэний амин үзүүлэлтийг хянаж, тогтвортой байлгах нөхцөлийг бүрэн бүрдүүлж, тээвэрлэлтийн үед өвчтөний аюулгүй байдлыг ханган, тасралтгүй хяналт тавьж эмчээс эмчид шилжүүлж, гардан хүлээлгэж өгөх;

5.3. Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төвүүд эмнэлзүйн чиглэлээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр шуурхай хангаж ажиллах;


Зургаа. Мэдээллийн урсгал

6.1. Эрүүл мэндийн байгууллага бүр өдөрт тутмын эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн burtgel.mohs.mn хаягаар бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөх өдөр бүрийн 9 цагт илгээх;

6.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв Эрүүл мэндийн яаманд холбогдох мэйлээр мэдээллийг нэгтгэн ирүүлэх;

6.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэнд шуурхай үзүүлэхэд тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газарт хандаж болно.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10 өдрийн 1/13 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ХӨЛ ХОРИОНЫ ХУГАЦААНД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД
ЗАЙЛШГҮЙ ХАМРАГДАХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗОРЧИХ ЭРХИЙН ЗӨВШӨӨРЛИЙН
ХУУДАС**

Эмнэлгийн нэр _____

1. Эцэг /эх/-ийн нэр _____ Нэр _____ Нас _____

РД: _____

2. Хүйс /зур/ эр, эм

3. Оршин суугаа хаяг _____

4. Зайлшгүй хамрагдах шаардлагатай эмнэлгийн тусламжийн төрөл _____

5. Эмчилгээнд хамрагдах хугацаа:

Долоо хоногт _____ удаа _____ цагаас _____ цагийн хооронд.

Зөвшөөрлийн хуудас бичсэн

Тамга:

Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

гарын үсэг _____ гарын үсгийн тайлал _____

2021 оны 02 дугаар сарын өдөр